



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 13 өдөр

Дугаар А/569

Ховд

Жишиг гудамж /Эрдэнэбүрэн сум/-ны
ажлыг хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 1 дүгээр хавсралтын 2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Хос мөнх дөл констракшн” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Жишиг гудамж /Эрдэнэбүрэн сум/-ны ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч: Б.Баярсүх

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Д.Нямтулга

- Мэргэжлийн хяналтын газрын
барилгын техникийн хяналтын улсын байцаагч

Б.Түмэндэмбэрэл

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ц.Цолмонбаатар

- Стандарт хэмжил зүйн хэлтсийн
салбар сан хариуцсан мэргэжилтэн

У.Цэрэнтогтох

- Эрдэнэбүрэн сумын Засаг дарга

Б.Түмэнжаргал

- Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

С.Батдорж

- Аймгийн Архивын тасгийн дарга

Б.Сугар

- “Хос мөнх дөл констракшн” ХХК-ийн захирал

Zah A/569 Kh

02 2873

2.

Нарийн бичгийн
дарга: Б.Жамбалдорж - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын мэргэжилтэн

2. “Хос мөнх дөл констракшн” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган шалгаж, өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

3. Дээрхи ажилтай холбогдолтой гарах зардлыг захиалагчийн хяналтын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН